

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны хоёрдугаар сарын 26-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Булган аймгийн Засаг даргын Д.Эрдэнэбатын 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/120 тоот албан бичгээр Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, уг сонгон шалгаруулалтыг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
2	Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Стандартчилал, техникийн зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Загдрагчаагийн Отгонбаярыг Стандартчилал, хэмжил зүйн газрын Стандартчилал, техникийн зохицуулалтын газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Стандартчилал

		хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөрт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Итгэмжлэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Сүхбаатарын Ганцэцэгийг Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Итгэмжлэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөрт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөрийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг өөрчлөн томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 02 дүгээр сарын 23-ны өдрийн 1/108 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэнг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 11-д “салбар зөвлөлийн” гэсний дараа “дарга-яамны</p>

		<p>Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн" гэж нэмэх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга С.Магнайсүрэнд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Онцгой байдлын ерөнхий газрын 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 1/383 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга Түвшингийн Бадралыг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 2-т "Тогоочийн Дуламдорж" гэснийг "Түвшингийн Бадрал" гэж өөрчилөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Т.Бадралд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Төрийн албаны зөвлөлийн Хууль зүйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын</p>

		<p>2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 3/527 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хууль зүйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Цэенгийн Цэнгэлмааг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 12-т "...мэргэжилтэн Нямсүрэнгийн Наранчимэг" гэснийг "..... ахлах мэргэжилтэн Цэенгийн Цэнгэлмаа" гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлмаа үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газар, Тахарын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Хоёр"-ын 12-т "Төрийн</p>

		<p>албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэсэн хэсгийн</p> <p>2) “Есдүгээр газрын орлогч, Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга” гэснийг “Тагнуулын ерөнхий газрын дэд дарга” гэж,</p> <p>3) “Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга” гэснийг “Тамгын газрын дарга” гэж,</p> <p>4) “Нэгдүгээр газрын орлогч дарга” гэснийг “Нэгдүгээр газрын дарга” гэж,</p> <p>5) “Хоёрдугаар газрын орлогч дарга” гэснийг “Хоёрдугаар газрын дарга” гэж,</p> <p>6) “Улсын шифрийн төв албаны дарга” гэснийг “Аравдугаар газрын дарга” гэж,</p> <p>7) “Аюулгүй байдлын албаны дарга” гэснийг “Аюулгүй байдал, дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга” гэж,</p> <p>8) “Архив бүртгэлийн хэлтсийн дарга” гэснийг “Мөрдөн байцаах хэлтсийн дарга” гэж</p> <p>9) “Хүний нөөцийн хэлтсийн дарга” гэснийг “Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга” гэж тус тус өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 25 дугаар тогтоолын 2 дугаар</p>
--	--	--

		<p>хэсэгт баталсан Төрийн албаны зөвлөлийн Тахарын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнээс “Тахарын ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн дарга”, “Тахарын ерөнхий газрын хуулийн хэлтсийн дарга”, “Тахарын ерөнхий газрын дотоод аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга” гэснийг хасаж, бүрэлдэхүүнд “Нийслэлийн тахарын албаны дарга”-ыг нэмж оруулах.</p> <p>2. Мөн тогтоолын 2 дугаар хэсгийн “Тахарын ерөнхий газрын Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн” гэснийг “Тахарын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн” гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

